

**Эрдэс баялгийн эдийн засаг**

**ЭРДЭС БАЯЛГИЙН НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

С.АВИРМЭД  
МУИС

Геологи газар зүйн сургууль

**Тулхүүр уг: Эрдэс баялаг, геологи эдийн засгийн үнэлгээ, техник-эдийн засгийн үндэслэл, ашигт малтмалын орд, нөөц баялаг, кондиц**

**1. Эрдэс баялгийн судалгаа, ашиглалтын өргөн хүрээтэй асуудлууд**

Олон талтай, олон чиглэлийн үйл ажиллагаатай геологийн судалгааны нэг гол зорилт бол эрдсийн баялаг буюу ашигт малтмалыг олох, илрүүлэх, улмаар ордын нөөцийг тогтоох гэж үзэж болно.

Геологи-хайгуулын ажлын нэг гол евермэц онцлог бол энгийнээсээ нарийн руу чиглэсэн, үе шаттай, дэс дараатай шинжлэх ухаан үйлдвэрлэл хосолсон танин мэдэхүй үйл ажиллага юм гэж манай эрдэмтэд тодорхойлсон байдал. Үүнийг геологийн судалгааны нэг зарчим, бүр цаашилвал, хуульчлах ёстой зарчим гэж үзэж байна.

Энэ өгүүлэлд эрдэс баялгийн судалгаа ашиглалтын маш өргөн хүрээтэй асуудлын талаар авч үзэхгүй, зөвхөн дэс дараалсан үе шаттай үйл ажиллагааны нэг бүрэлдүүн хэсэг болсон геологи-хайгуулын ажлын үндсэн үе шатууд, тэдгээрт өгөх геолог-эдийн засгийн үнэлгээ, техник-эдийн засгийн үндэслэлийн талаар Та бүхэнтэй санал, бодлоо хуваалцах гэсэн юм. Үүнийг би эрдсийн баялгийн нөөцийн үнэлгээ гэж товчлоод байгаа юм. Эрдсийн баялгийн илрүүлэх, судлах зорилготой геолог хайгуулын ажил нь олон жил Монгол улсад мөрдөгдөж байгаа заавар, стандартаар бол:

- зураглалын,
- эрлийн,
- хайгуулын гэж энгийнээсээ нарийн руу чиглэсэн, дэс дараалсан тодорхой зорилготой үндсэн гурван үе шатад хуваагддаг,

цаашилаад эдгээр нь дотроо хэдэн хэдэн дэд үе шатуудад хуваагддаг гэдгийг манай бүх геологич хэлэх бөгөөд үүнийг миний мэдэхийн 1997 он хүртэл геологийн судалгаа явуулдаг мэрэгжилтэн, байгууллага ягштал мөрдөж ирсэн билээ. Гэтэл 1997 оны "Ашигт малтмалын тухай хууль" гэгч мөрдөгдөж эхэлсэнээр геологи-хайгуулын ажлын үндсэн үе шат, эрдсийн баялгийн судалгааны дэс дарааллыг бүрмэсэн устгаж, "хайгуул" гэх ганцхан ойлголтыг бататгасан нь, Монгол улсын нутаг дэвсгэрийг хайгуулын лицензээр бүрхэж, нүүдэлчин малчин ардын амьдралыг бусниулж, онгон дагшин байгалийг сүйтгэсний хор уршгийг бүх нийтээрээ ярьж байгаа бөгөөд цаашид ч ярьж хэлэлцэх учир үүнийг орхиж, Монгол улсын геологийн судалгааны бодлогыг алдагдуулж, үндсэндээ Монгол улсын геологийн албыг устагасан ноцтой завхрал болсон гэдгийг л тэмдэглэх байна. 1998 он гэхэд геологийн судалгааны ажлын үндэс болсон геологийн үйлдвэрлэл, шинжилгээний байгууллагыг татан буулгаж, өргөн уудам нутгийн геологийн тогтоцыг судлах бодлогоор баруун, зүүн, хойт, емнөд, төв районд


байгуулсан, үйлдвэрлэлийн хангалттай бааз бүхий 6 геологийн экспедицийн хувьчлах нэрийдлээр устгаж, олон арван жилийн арвин их туршлагатай, оюуны өндөр чадавхитай хэдэн зуун геологичдыг гудамжинд гаргаж, ажилгүйчүүдийн

## ГАЗАР ДООРХИ УСНЫ БОХИРДЛЫН СУДАЛГААНЫ ДҮН

Эгнээнд шилжүүлсэн билээ. Энэ талаар улс төрийн, нийгмийн дүгнэлтийг тусад нь өгөх шаардлагатай.

Юуны өмнө, эрдэс баялгийн судалгааны гол үндэс нь геологийн судалгаа болдог. Чухамхүү геологийн судалгаагаар бодитой, үндэслэлтэй судлагдсан эрдсийн баялгийн тоо хэмжээ л ард нийтийн баялаг, төрийн өмч болдог билээ.

Эрдэс баялгийн неөцийн үнэлгээний агуулгыг тодорхойлох гол хүчин зүйлүүдэд геологийн, инженерийн, эдийн засгийн, цаашилаад нийгмийн өргөн хүрээтэй асуудлуудыг хамарна. Үүнийг схемчлэн зураг 1-д үзүүллээ.



Зураг 1. Эрдэс баялагийн үнэлгээний бурдэл, агуулга


Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны үндэслэлтэй, эрдсийн баялгийн үнэлгээг олон төрлийн мэрэгжлийн, оюуны өндөр чадавхитай эрдэмтэд мэрэгжилтнүүд л боловсруулдаг юм. Геологи хайгуулын ажлын эхний үе шатны эрдсийн баялгийн үнэлгээг мэдлэг туршлагатай цөөхөн мэрэгжилтэн хийх боломжтой байдаг бол урдчилсан хайгуулын дараахи шатнаас эхлэн боловсруулдаг техник эдийн засгийн тооцоо, үндэслэлийг төрөл бурийн мэрэгжлээр мэрэгжсэн шилдэг мэрэгжилтнүүд, томоохон ордын хувьд бол хэдэн арван эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд оролцсон хамт олны нүсэр их хөдөлмөр шаардсан оюуны томоохон бутээл юм.

Эрдэс баялгийг судлах, ашиглах үндэслэлийн гол дүгнэлтийг зөвхөн эдийн засгийн үр ашгийн тооцоогоор хийдэг. Эрдсийн баялаг, ашигт малтмалын орд нь өмч мөн. Манай улсын Үндсэн хуулийн заалтаар бол энэ өмч нь ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байна. Дэлхий олон улс оронд байгалийн баялаг, тэр дотроо ашигт малтмал бол олон нийтийн өмч гэж тодорхойлогддог. Энэ нь манай ард түмний өмч гэсэн ойлголттой яв цав нийцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, эрдэс баялгийг ашигласанаас гарах ашиг, орлогыг ард түмэн, олон нийтэд хувиарлах ёстой, тэд түүнээс хүртэх бүрэн эрхтэй гэж ойлгогдож байгаа юм. Эрдсийн баялгийг ашигласанаас, манай ойлголтоор бол ард түмэнд, дэлхийн олон орны жишгээр бол олон нийтэд хувиарлах буюу хүртээх хувь хэмжээ нь олон хүчин зүйлээс шалтгаална. Энэ юуны өмнө тухай улс орны татвар, төлбөрийн бодлого, хуулиас шалтгаална. Энэ нь төрийн эдийн засгийн бодлогын том асуудал учир тусад нь нухацтай авч үзэх ёстой юм. Харин ард түмний буюу олон нийтийн энэ өмчийг эздэд нь яж, хэрхэн хүртээх, хувиарлах үйл ажиллагааны эх үүсвэр нь эрдсийн баялгийг зөв, бодиттой үнэлэхээс эхлэнэ. Тодоруулж хэлвэл, ашигт малтмалын ордыг ашиглах техник-эдийн засгийн тооцоо, үндэслэлээс эхлэнэ. Ийм үндэслэл, тооцоог хийх гол зорилго нь олон нийтийн өмчийг эздэд нь аль болох хүртээмжтэй хувиарлах зарчмыг баримталж боловсруулагддаг байх ёстой.

## ГЕОЛОГИЙН МЭРГЭЖИЛТЭНД БЭЛТГЭЖ ЭХЭЛСЭНИЙ 50 ЖИЛИЙН ОЙД

Энэ хэдийгээр татвар, төлбөрийн хэмжээнээс гол хамааралтай боловч, тухайн үндэслэл тооцоо хийж байгаа байгууллага мэрэгжилтэний мэдлэг чадвар, шудрага байдал, тэр ч байтугай, тэдний хүмүүжил, ёс суртхуунаас бас хамааралтай. Өмчийг эздэд хүртээх, хувиарлах, цаашлаад улс орны эдийн засгийн хөгжүүлэхийг гол зорилт болгосон үндэслэл, үнэлгээг хийхэд зарчмын гол гол асуудлуудыг төрийн бодлогоор хийх, зохицуулах шаардлагатай. Үүнд нийгмийн, улс төрийн гадаад бодлогын, дэд бүтцийн оновчтой шийдлүүдийг гаргах шаардлагатай болдог. Үйлдвэрийн цар хэмжээ, хэлбэр, бүтээгдхүүний хэмжээг төрийн бодлогоор зохицуулах шаардлагатай. Үүнийг зураг 2-т тоймлон үзүүллээ.

Зураг 2.



Зураг 2. Эрдэс баялагийн үнэлгээнд төрийн бодлогыг тусгах нь

Үйлдвэрийн хэлбэр гэх ойлголтод ХХК байх уу, ХК байх уу, эсхул үндэсний үйлдвэр байх уу, гадаадтай хамтарсан үйлдвэр байх уу, бүр концессийн үйлдвэр байх уу гэдгийг төрийн бодлогоор зохицуулах шаардлагатай. Үйлдвэрийн хүч чадал, бүтээгдхүүний тоо хэмжээ, бүтээгдхүүний нэр төрлийг төрөөс зохицуулах нь зүйтэй. Эс тэгвээс одоогоор тогтоогдоод байгаа нөөц баялаг нь зөвхөн өнөө үеийнхний өмч биш, энэ нутаг дэвсгэр дээр зуу зуун жил амьдах ирээдүй хойчийн, үр удамын маань өмч гэж ариг гамтай төрийн бодлогоор ашиглах ёстой. Оюутолгой, Тавантолгой мэтийн дэлхийн томмоохон ордуудыг 20-30 жил цэлмэж ашиглах биш, наад зах нь 100 гаруй жил ашиглаар тооцоолох нь ухаалаг бодлого болно. Түүхий эд буюу хагас боловс руулсан түүхий эд экспортлодог олон жил ужгирсан зуршилаасаа салах болжээ. Говийг бүсэд нээгдээд байгаа томоохон ордуудыг эрчим хүч, зам тээвэр, хот тосгоны нэгдсэн бодлогоор ашиглах нь монгол улсын хөгжилд огцом дэвшил авчирна гэдэг нь ойлгомжтой.

Гадаад бодлогын хувьд гэвэл, мөнхийн хоёр хөршөө үл огоорч, "уулын буга хараад унасан бухаа орхих" бодлого баримталж байгаа өнөөгийн төрийн бодлого хир зөв бэ гэдгийг тал талаас нь нягталж үзүүштэй.

Монгол улсын эрх ашигт нийцсэн, монгол түмэнд өмчийг нь хүртээх зорилготой эрдсийн баялагийн нөөцийн үнэлгээг төрийн бодлогоор, мэрэгжлийн өндөр түвшинд хийсэн үндэслэлээр л хийж болно.

Үүний сацуу эрдэс баялагийн нөөцийн тооцоо, үнэлгээг төрийн нэрийн өмнөөс авч хэлэлцэж зохих шийд гаргаж байгаа мэрэгжлийн байгууллага, мэрэгжилтнүүдийн дүгнэлт туйлын хариуцлагатай ажил, түүнээс улс орны хөгжил, та бидний амьдрал шууд хамаарна. Энэ нь заримдаа хувь хүний хүмүүжил, ёс суртхуунаас ч хамааралтай болдог.

Геологи эдийн засгийн үнэлгээ, ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн чанар, бодит шийдлүүд нь түүнийг боловсруулах үед мөрдөх хууль тогтоомж, заавар журам, стандартаас бас ихээхэн хамааралтай.

## 2. Эрдэс баялгийн үнэлгээ боловсруулахад мөрдөх хууль эрх зүйн үндэсийн талаар

Эрдэс баялгийг судлах, ашиглах үйл ажиллагааг явуулахад:

- Ашигт малтмалын тухай хууль,
- Газрын хэвлэлийн тухай хууль,
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх тухай хууль” зэрэг дагалдах хуулиудаас гадна, “Ашигт малтмалын нөөц, нөөц, баялгийн ангилал” зэрэг зарим заавар, стандартыг эс тооцвол, энэ өргөн хүрээтэй асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн баримт бичиг туйлын хангалтгүй байна.

“байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх тухай хууль” зэрэг дагалдах хуулиудаас гадна, “Ашигт малтмалын нөөц, нөөц, баялгийн ангилал” зэрэг зарим заавар, стандартыг эс тооцвол, энэ өргөн хүрээтэй асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн баримт бичиг туйлын хангалтгүй байна.

Хамгийн наад зах нь эрдэс баялгийн үнэлгээний гол үндэс болсон “Ашигт малтмалын нөөц, нөөц баялгийн үнэлгээний ангилал” гэхэд л аль арав гаруй жилийн өмч боловсруулсан, өнөөг хүртэл ихээхэн маргаан зөрчил дагуулсан, нийтийн өмч болсон эрдсийн баялгийн чанар тоо хэмжээг бодиттой гаргахад хүндрэл төвөг учруулсан гэх зэрэг олон дутагдал ажиглагдсан боловч өнөөг хүртэл өөрчлөөгүй л байна. Чухам энэ шалтгаанаар л монгол улсын эрдэнэсийн сан хөмрөгийн хэмжээ бодиттой үнэлгэдэж чадахгүй байна.

Зөвхөн үнэн бодиттой тогтоогдсон нөөцед тулгуурлан тухайн орд, объектийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хийгдэх учиртай. Гэтэл үүний үндэс болсон нөөцийн ангиллал нэг мөр болгоогүй, Монгол улсын эрдсийн баялгийг сан хөмрөгийн үнэн бодиттой тогтоох ажил хийгдсэнгүй хориод жил өнгөрлөө.

Геологи-эдийн засгийн үнэлгээ, ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл нь өөрийн гэсэн хатуу хэв загвартай, тодоруулж хэлвэл, тусгай, стандарт, заавар, журмын дагуу хийгддэг, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийнг ажил билээ. Гэтэл Монголын ард түмний гол өмч болсон эрдэс баялгийг тэдэнд хүртээх зарчмыг тусгасан стандарт, заавар өнөөг хүртэл үндсэндээ алга байна. Олон жилийн турш мөрдөгдөж ирсэн заавар, журам хангалттай байдаг боловч, түүнийг мөрдөхгүй байна.

Зах зээлийн орнуудад мөрдөгддөг гэх стантарт, зааврыг хуулбарлан орчуулахыг зарим бүлэг хүмүүс санал болгож байгаа боловч, тэр нь одоогоор манай улсад баримталж байгаа, мөрдөгдөж ирсэн хайгуулын аргачлал, нөөцийн тооцооны аргачлалтай зөрчил үүсгэж, хүндрэл бэрхшээл үүсгээд зогсохгүй буруу дүгнэлтэд хүргэх ч нөхцлийг бүрдүүлж болзошгүй.

Одоогийн мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулинд эрдсийн баялгийг үнэлэхэд Монгол улс, ард түмний язгуур эрх ашгийг тусгасан заалт үндсэндээ байхгүй. Харин газрын хэвлэлийн тухай хуулинд, ашигт малтмалыг газрын хэвлэлийгээс бүрэн гүйцэд авч ашиглах тухай, ашигт малтмалыг сорчилж ашиглахгүй байх тухай заалтууд бий боловч түүнийг мөрдлөг болгохгүй байна.

Эндээс ямар дүгнэлт хийж болох вэ гэхээр, сүүлийн хориод жилд эрдсийн баялгийг судлах ашиглах, ялангуяа ашигт малтмалын ордыг ашиглах техник-эдийн засгийн үнэлгээг хийх стандарт, заавар байхгүй байна, ард түмний өмч болсон нөөц баялгаа ч зөв үнэлж чадахгүй байна, үүнтэй уялдаад ордыг ашиглах үр ашгийн тооцоог ч гаргахдаа ихээхэн алдаа дутагдал гаргаж байна гэдгийг дараахи жишээ баримтаар нотлогдох болно.

**3.1000 гаруй орд, уурхай хаана байна.**

Одоо манай улсад төрөл бүрийн эрдэс баялгийн 1000 нилээд давсан ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогджээ.

Үүнийг наад зах нь 1000 ашигт малтмалын орд, мянган уурхай байна, бүгд ашигтай ажиллах ёстой гэж ойлгож болно. Энэ зөвхөн тухайн орд бурийг ашиглах техник-эдийн засгийн тооцоо, үндэслэлээр л нотлогдсон байх учиртай гэдэг нь бас ойлгомжтой. Тэгвэл энэ олон тооцоо судалгааг хэн үзсэн юм бэ, хянасан юм бэ. Яагаад түүний үр ашиг нь бидэнд мэдрэгдэхгүй байна гэдгийг иргэн бүр, төрийн эрх бүхий байгууллага, асуудал хариуцсан эрх мэдэлтэнээс асуух хэрэгтэй. Лав л өнөөдөр 1000 давсан уурхай үйлдвэр ажиллаагүй, улс орон тэр дагуу хөгжөөгүй, бидний амьдрал тэр хэмжээгээр дээшлээгүй гэдэг ойлгомжтой. Энэ далимд тэмдэглэхэд, олборлож ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиг ашигтай эрдэс баялгийн хуримтлалыг ашигт малтмалын орд гэнэ, орд бол уурхай мөн, орд байгаа бол ашигт малтмалын нөөц нь бодиттой тогтоогдсон байж таарна зэрэг ойлголтыг энэ чиглэлээр суралцах байгаа захын оюутан хэлнэ.

100 гаруй алтны уурхай ажиллах байгаа гэж ярьдаг, барилгын хайрга элс ухдаг нилээд хэдэн уурхай бий биз. Хайлуур жоншны хэдэн арван уурхайнцар бий биз. Үлдсэн хэдэн зуун уурхай хаана байна. Хэрэв уурхай нь ажиллагч бол түүнийг ашиглах техник-эдийн засгийн тооцоо, үндэслэлүүд нь хийгдсэн байх ёстой. Тэд хаана байна. Хэзээ 1000 уурхай ажиллах бидний амьдрал дээшлэх вэ. Ашиглалтын тусгай зөвшөөрөл авчихаад уурхайгаа яагаад ажилуулахгүй байна. Үүнд эрх мэдэлтнүүд хариулна гэж найдаж байна.

**4. Эрдэс баялгийн үнэлгээнд гарч буй ноцтой алдааны талаар.**

Бидний амьдрал, монгол улсын хөгжилд бодит нелөө үзүүлэх ашигт малтмалын хэдэн хэдэн томоохон ордын нөөцийн тооцоо, тэдгээрийг ашиглах техник эдийн засгийн үндэслэлд шүүмж, экспертийн дүгнэлт хийх надад завшаан тохиолдсон юм.

Би сүулийн арав гаруй жилд Бороогийн алтны үндсэн орд, Гацууртын алтны үндсэн орд, Оюутолгойн зэс-алтны орд, Тавантолгойн нүүрсний ордуудын нөөцийн тооцоо, тэдгээрийг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлд экспертийн дүгнэлт, шүүмж хийсэн билээ. Эдгээр ордуудын нөөцийн тооцоо, техник-эдийн засгийн үндсэн шийдлүүдэд гарсан ноцтой алдааны талаар сонирхуулъя. Энэ ноцтой алдаануудыг хэд хэдэн бүлэгт системчлэн хувааж болно. Үүнд:

-Хайгуулын бүрэн гүйцэд хийдэггүй, хагас дутуу хайгуул хийсэн болоод ашиглахыг яаравчилдаг нийтлэг дутагдал бий.

-Ордын нөөцийг бүрэн гүйцэд тооцоолдогтуй, сорчилж авах хандлага газар авсан

-Нэг ордыг хэд хэд хувааж авдаг, үнэлдэг

-Эцсийн бүтээгдхүүн биш, зөвхөн түүхий эд хагас боловсруулсан түүхий эд гаргахаар тооцоог хийдэг.

-Бүтээгдхүүний үнэ, өртгийн тооцоонд гаргаж буй алдаанууд

-Дэд бүтэц, хот тосгоны шийдэлд гаргаж буй алдаанууд зэргээр үргэлжлүүлж болно.

Энд би зөвхөн ноцтой алдаануудын талаар товч дурдлаа. Энэ алдаанууд санаатай юу, санамсаргүй юу, ямар шинжтэй вэ гэдгийг тусад нь дүгнэх шаардлагатай.

Одоогоор хайгуулын үр дүнд нөөц нь урдчилсан байдлаар тогтоогдоод байгаа монгол улсын хувьд томоохонд орох алтны үндсэн орд бол Гацууртын орд юм.

Хайгуулын ажлыг 2005 онд дуусгасан, хайгуул дууссан, олборлоход бэлтгэгдсэн гэж ярьцаадаг. Орд гүн рүү гээ гүйцэд, бүрэн хайгдаагүй байна. Хайгуулын ажлыг үндсэнд нь 1100 дугаар горизонтоор буюу гадаргуураас 200-250 м –ийн гүнээр хязгаарласан байна. Өөреөр хэлбэл ил аргаар, эхний эзлжинд авч болох гүнээр хязгаарлажээ. Худрийн биет гүн рүүгээ үргэлжилж байна, хайгуулыг гүйцэд хийсэнгүй гэдгийг нотлох хэд хэдэн баримт байна. Үүнд:

•Төв болоод Үндсэн хэсэгт өрөмдсөн бүх өрөмдлөгүүд худрийн биетийг нэвт гараагүй, худрийн биет дунд зогссон,

•9-р секц дээр өрөмдсөн 256-р цооног нь 850-900 дугаар хүртэл буюу 480 м урттай бөгөөд энд худэржилт илэрч байна.

•Мен 800 м гүнтэй цооногт ч худэржилт илэрсэн.

Энэ бүхэн нь алт бүхий худэр одоогийн нөөц баялаг нь тооцоологдсон 250 гүнээс 3 дахин гүнд худэржилт илэрч байгааг нотлох бөгөөд цаашид нөөц баялаг үлэмж всех боломжтойг харуулж байна.

Энэ ордын хувьд худрийн хэмжээний хувьд ч, алтны хэмжээний хувьд ч геологийн баялаг нь үйлдвэрийн нөөцөөсөө 2.5-2.3 дахин их байна. Өөреөр хэлбэл, хайгуулаар тогтоогдсон баялгийн тал илүү хувийг газрын хэвлийд үлдээжээ. Гүн рүүгээ алтны худэржилт бүрэн гүйцэд тогтоогдоогүй, нөөц баялгийн хурээг тодорхойлоогүй гэдгийг тооцож үзвэл, энэ ордын алтны нөөц баялаг үлэмж ёсах нь тодорхой байна.

#### Оюутолгойн хувьд байдал бүр ч ноцтой.

1. Гол алдаа нөөцийг нэг мөр болгож үнэлж чадаагүй. Хайгуулаар тогтоогдсон 45 сая тонн нөөц баялгаас 22 тонныг нь буюу тал хүрэхгүй хувийг, 1800 тонн алтнаас 770 тонн буюу 43 хувийг ашиглахаар тусгасан нь газрын хэвлийн баялгийг сорчлох төдийгүй, цэлмеж авах нөхцлийг бүрдүүлжээ. Үлдсэн нөөц баялгийг хэзээ яж авах, эсхүл хаях эсэх нь тодорхой бус байна.
2. Үйлдвэрийн хүч чадлыг дээд зэргээр, хамгийн их байж болох хувилбараар өгсөнөөс одоогоор тогтоогдоод байгаа усны нөөц хүрэлцэхгүй болсон,
3. Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурах үед энэ үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг 4 тэрбум ам. доллар гэж зарлаж байсан бол ТЭЗҮ-д тэр даруй 27.5 хувиар ёсёж 5.1 тэрбум ам.доллар болсон,
4. Монгол улсын хууль, журамд тусгагдаагүй роялти нэрийдэлтэй орлогыг(2 тэрбум 500-гаад сая доллар) гадаадын компаниуд өөр хоорондоо зувчуулах оролдлого хийж, монголд ноогдох үлэмж ашгийг зохиомолоор багасагасан,
5. Ордыг ашиглахад эцсийн бүтээгдхүүн гаргах буюу зэс хайлуулах завод байгуулах хувилбарын тооцоо хийх удаа дараагийн хүсэлтийг үл хайхарч, түүхий здийг 100-гаад км зайд автомашинаар БНХАУ-руу зөөх хамгийн тааруу хувилбараар ТЭЗҮ-ийг боловсруулсан,
6. Дэлхийн том ордыг ашиглахад үйлдвэрийн дагуул хот байгуулах асуудлыг орхигдуулж, ажиллагсадыг Хан богд, Манлай зэрэг сумдад тараан байршуулж, ажиллагсадын нийгмийн асуудлыг үндсэнд нь орхигдуулсан,
7. Канад улсын харьяалалтай хоёр компани нэг ордыг хэсэгчлэн хувааж, улмаар баялгийг олборлосоноос гарах ашгийг 20:80, 30:70-ийн харьцаатайгаар хувааж авах урдчилан гэрээ хэлцэл хийсэн,
8. Кондицийн нэг гол үзүүлэлт болох захын агуулга болон дундаж агуулгыг NSR-ээр тодорхойлох нэрийдлээр ордын аль баян агуулгатай хэсгийг сорчлон ялгах нөхцлийг бүрдүүлжээ. Үүний нотолгоо бол Хойт Хюгагийн ордын NSR-ийн 20 долларт, 0.9-1% зэс, Өмнөт Хюгагийн 10 долларт 0.6-0.7% зэсийн агуулга тус

тус харгалзаж байгаа бөгөөд чухам энэ агуулгаар балансын гэх нөөцийн хүрээг татсан бололтой. Нөөц тооцоолох кондицийн гол параметр болох захын агуулгыг ингэж өсгөсөн нь ордын аль баян хэсгийн сорчилж авах нөхцөл бүрдүүлээд зогссонгүй, балансын гэж нэрлэгдэх нөөцийн хэмжээг үлэмж буруулж байгаа юм. Мөн үүнээс гадна, далд уурхайгаар олборлох худрийн минимум өргөнийг 145-м-ээр авсан нь мөн их хэмжээний нөөцийг балансын бусад оруулахад нөлөөлжээ.

Одоо ид шуугиан үүсгээд байгаа Тавантолгойн нүүрсний ордыг ашиглавал бидэнд юу өгөх вэ гэдэг туйлын ойлгомжгүй байна. Энэ ордыг ашиглавал монголчуудад ямар өгөөжтэй вэ, аль хир удаан, олон жил ашиглах вэ гэдэг бас туйлын бүрхэг байна. Гол асуудал энэ орд хичнээн нөөцтэй вэ гэдэгт байна. Бараг хүн болгон, тэр дутмаа төрийн өндөр албан тушаалтнууд, эрх мэдэлтнүүд энэ ордын нөөцийг 6.5 тэрбум тонн гэж улиг болтол давтаж байна. Тэгвэл энэ ордын “жинхэнэ” нөөц дээрхээс 6-7 дахин бага гэдгийг геологийн сургуулийн захын оюутан нотолж чадна. Ойлголтын зөрчил, зөрөө юундаа байна гэхээр нөөц, нөөц баялаг гэх ойлголтод байгаа юм. Хуучин тогтолцооны үед тодорхойлсон 6.5 тэрбум гэх цифр нь үйлдвэрийн нөөц, мөн таамаг нөөцийн нийлбэр юм. Олон улсад мөрдэж байгаа өнөө цагийн нийтлэг ангиллаар бол Тавантолгойн ордын бодит, баттай нөөцийн нийлбэр нь 1 тэрбум тонн хүрэхгүй. Үүний олон улсын нэр томъёог “резерв” хэмээдэг. Таамаг нөөц буюу одоогоор нөөц баялаг хэмээн монголоор оноогоод байгаа ойлголтыг олон улсын хэлээр “ресурс” хэмээнэ. Ресурсийг техник-эдийн засгийн үндэслэлд авдаггүй, зөвхөн резервэд тулгуурлаж ийм тооцоог хийдэг гэдгийг бас л захын оюутан мэднэ. Энэ мэтийн төөрөгдлийн хор уршиг, үр дагавар хэмжээлшгүй, цаг, цаас их шаардагдах учир энэ асуудлыг үүгээр хязгаарлай.

Гацууртын ордын хувьд нөөц, баялгийг нь гүн рүү нь гүйцэд судлаагүй яаравчлан үнэлгээг хийж, шууд ашиглахыг завдаж байгаа нь, үлдсэн нөөцийг ямар үр ашигтай ашиглах, эсхүл огт ашиггүй объект үлдээж, газрын хэвлийн баялгийг сэглэж хойч үед ашиггүй болох нөхцлийг ч бурдуулж байж болох юм.

Оюутолгойн хувьд, өнөөгийн техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу ашиглах юм бол, зөвхөн канадын компаниудад богино хугацаанд өндөр үр ашиг өгөх, монголд туйлын бага ашигтай, бидэнд ашигласан ашиглаагүй ялгаагүй, өгөөж муутай гэдгийг л мэрэгжилтний хувьд нотолж чадах байна. Энэ талаар тусгай дүгнэлт бидэнд бий.

Ашигт малтмалын ордуудыг аж ахуйн эргэлтэд оруулж, бидний амьдрал дээшилж, улс орон хөгжих эсэх нь зөв, бодиттой боловсруулсан техник-эдийн засгийн үндэслэл, тооцоонаос эхлэнэ, эрдэс баялгийг баазыг хэрхэн үнэлсэнээс шалтгаална, эцсийн эцэст үүнээс хамаарч төр, засгийн шийдвэр гардаг билээ.

### 5. Эрдэс баялгаа үр өгөөжтэй ашиглах анхны зөв алхамууд

Аливаа үйлсийг бүтээхэд эхлэлийг зөв тавих, барилгаар бол бат бэх суурь тавих нь чухал билээ. Үүнийг монголчууд “гараа сайн бол бария сайн” ч гэдэг бас эсрэгээр буруу эхэлсэн бол “буруу замаар будаа тээх” ч гэж хэлдэг. Чухамдаа бол бид сүүлийн хориод жилд буруу замаар будаа тээгээд байна.

Эрдсийн баялгийг үр өгөөжтэй, нийт олондоо хүртэлтэй ашиглах нь ашигт малтмалын ордыг зөв үнэлэхээс, тодоруулж хэлвэл, ашигт малтмалын ордын техник-эдийн засгийн үндэслэл, тооцоог зөв бодиттой хийхээс эхлэнэ. Үүний тулд өнөөгийн хэлээр бол зөв менежментийн, хуучин ойлголтоор бол удирдлага зохион байгуулалтын дорвитой өөрчлөлт хийх, цаашилбал, түүнийг боловсруулах арга аргачлалын, мөрдвэл зохих хууль эрх зүйн, заавар, стандартыг боловсронгуй болгох арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй.

Газрын хэвлүйн баялаг нийтийн өмч ард түмний өмч гэх үндсэн хуулийн заалтаас үндэслэн төрийн бодлогоор, ард түмний оролцоо хяналтыг өргөтгөх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Үүнд:

**Менежементийн чиглэлээр.**

-Бодлогыг боловсруулдаг, түүнийг хэрэгжүүлдэг, хянадаг төрийн, олон нийтийн байгууллагуудын эрх үүргийг өргөжүүлж, боловсронгуй болгох хэрэгтэй. Үүнд юуны өмнө төрийн мэдлийн эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудыг бий болгох шаардлагатай.

-Эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн тайлан, ажлыг авч хэлэлцдэг, дүгнэлт, шийд гаргадаг үйлдвэрийн болоод шинжлэх ухааны ажлын дадлага туршлагатай эрдэмтэд, мэрэгжилтнээс бүрдсэн эрдмийн зөвлөл, ажлын хэсгийн тусгай шалгуураар зохион байгуулах хэрэгтэй. Мөн үйлдвэрлэл, эрдэм мэрэгжилтнүүдэд итгэл өгч “өндөр ур чадвартай мэрэгжилтэн” буюу QP ажиллуулдаг гадаадын туршлагыг ч хэрэгжүүлж болно. Үүнийг хэрэгжүүлж байгаа манай өнөөгийн туршлагаас харахад , ямарваа нэг тодорхой шалгуургүйгээр тохиолдолын хүмүүсийг компаничилан бөөнөөр бэлддэг, бас аливаа том тайлан, бүтээлийг боловсруулах, дүгнэлт өгөхдөө хариуцлагын асуудлыг голлон биш, мөнгө, ашгийг урьтал болгодогоос аливаа ордын эдийн засгийн үр өгөөжийг олон нийтэд, улс оронд үр өгөөжтэй ашиглах шалгуур алдагдаж, тухайн компанийд илүү үр өгөөжтэй байх нөхцлийг бүрдүүлсэн шийд, дүгнэлт элбэг гарах болсон нь тодорхой болжээ.

-Дээрхтэй уялдаад тодорхой асуудал хариуцсан албан тушаалтан, мэрэгжилтний үүрэг хариуцлагыг өндөржүүлэх нь гол чухал асуудал болж байна. Үүнтэй холбогдуулан аливаа ашигт малтмалын ордын түүхий эдийн бааз эдийн засгийн үр ашгийн талаар санаатайгаар буруу дүгнэлт гаргасан албан тушаалтан , мэрэгжилтэнд, албан тушаал бууруулах, халахаас эхлээд онц ноцтой хохирол учруулсан бол эрүүгийн хэрэгт татах, хохирлыг төлүүлэх хүртэл арга хэмжээ авах хэрэгтэй.

**Хууль эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох чиглэлээр**

Ашигт малтмалын ба бусад хуулинд өөрчлөлт оруулах замаар дараахи зүйлийг заавал тусгах хэрэгтэй. Үүнд:

-Геологи-хайгуулын ажлын үндсэн үе шат, тэдгээрт өгөх үнэлэгээ, дүгнэлтийн талаар,

-Геологийн судалгааны ба ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүргийг нарийвчилж боловсронгуй болгох,

-Эрдсийн баялагийг ашигласанаас ард олонд хүртээх, улсын төсөвт төлөх татвар, төлберийн хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн дахин хянах,

-Урд өмнө нэгэнт тогтоогдсон, одоо тодорхойлогдож байгаа ашигт малтмалын нөөц, баялагийгүнэлэх, улмаар улс орны нийт нөөц баялаг, улсын эрдсийн баялагийн сан хөмрөгийг тогтоох зорилгыг гол болгосон нөөцийн ангиллыг хэлэлцэж баталгаажуулан нэн даруй мөрдөж эхлэх нь хамгийн гол чухал зорилтын нэг болжээ.

-Аливаа ашигт малтмалын орд, ажиллаж байгаа болон шинээр байгуулах уурхайн дүүрэгт геологийн судалгаа явуулах аргачилсан заавар, стандартыг боловсруулж батлан хэрэгжүүлэх,

-Эрэл хайгуулын үе шат бүрд геологи-эдийн засгийн үнэлгээ хийх, нөөцийн тооцооны кондиц боловсруулах, нарийвчилсан ба олборлолтын хайгуулын үр дүнгээр техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах заавар, стандартыг боловсруулах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлсэнээр нийт ард түмний өмч болсон эрдсийн баялагийг үр ашигтай ашиглаж, үр шимийг нь эздэд нь хүртээх нөхцөл бүрдэнэ.